



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/111

Хархорин сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 3 дугаар баг усжуулах 1-3а тоотод Бат-Эрдэнэзуу хийдийн боловсролын байгууллагын зориулалтаар эзэмшиж байгаа 6209008080 нэгж талбарын дугаартай 7391м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу худалдаа, нийтийн үйлчилгээний төв цогцолборын зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмшигч Бат-Эрдэнэ зуу хийдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг Бат-Эрдэнэзуу хийдэд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны А/88 дугаар захирамж, газрын 0000292915 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ



401100221